



ХЭРЭГЖҮҮЛСЭНХУГАЦАА: 2020.07.25-08.05

Усан хангамж сайжруулах

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ: 2680000

Төсөл хэрэгжсэн газар

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум Цагаан уул БАХ. Гашууны эхний гүн өрмийн худгийг сэргээн засварлах төсөл

Төслийн зорилго

Хамгаалалтгүйгээс дарагдах, аних аюулд хүрээд байгаа цооногийг хур бороо, хаврын шар усаар зөөгдсөн хог хаягдал, элс шорооны хуримтлал, ойр орчмын хөрс малын хөлөөр талхлагдалтад шууд өртөхөөс сэргийлж, хүн амын эрүүл ахуйд сөрөг нөлөө үзүүлэх, усны хомсдолоос сэргийлж хамгаалалт барьж 40-50 метр насос тавин 100% хүчин чадлаар нь ажиллуулна.

. Төслийн зорилтууд

Цагаан уул БАХ-ын малчидтай хамтран худгийн гадуурх хамгаалалтыг 5 хоногийн хугацаанд барьж дуусгана. Энэ зорилтын хүрээнд дэх зардлыг малчдын байгууллагаас гаргана.

Худагт насосыг байрлуулж, усны хоолой, татуурга тросс, тог баригч болон бусад хэрэгслүүдийг 2 өдөрт суурилуулна.

Онгоцыг эсгэж гагнаж дуусгаад хайргаар манаас хийж цементээр бэхэлж суурилуулан 3 өдөрт хийж дуусгана.

Бэлэн болсон худагт мотор тавьж ажиллуулан багийн засаг дарга болон сумын комисст хүлээлгэн өгнө.

Үйл ажиллагаа

Уг худгийн гадуур 3 м урт, 2 м өргөн 2 м өндөр хэмжээ бүхий хамгаалалтын байрыг блокоор барьж гадна талыг цемэнтлэх ба нурууг модон материалаар хийж гүйцэтгэнэ. Худгийн цооногийг газраас дээш 30-50 см хэмжээтэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Хамгаалалтын гадна 3 метрийн урт бүхий 1 онгоц байрлуулна. Онгоцны гадуур 50 см-ийн цементэн эмжээр бүхий хамгаалалт хийж өгнө. Энэхүү үйл ажиллагааг СБАХ-ын тэргүүн БАХ-ын ахлагч нар хариуцаж 8 малчин 5 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэж дуусгана. Худаг ашиглах үед худаг хариуцсан малчин болон БАХ-ын ахлагч мотор насосыг ээлж дараатайгаар авч ашиглах ба болон зарим малчид өөрсдийн мотор насос ашиглаж болдог ийм байдлаар нь ундарга сайтай шавхагддаггүй сайн чанарын устай энэхүү худаг усаа

эзэнтэй болгож урт удаан хугацаанд ашиглах зарчмыг баримтална.

Худгийн хамгаалалт хийх энэхүү үйл ажиллагааг СБАХ-ын тэргүүн болон БАХ-ын ахлагч ажлаа бүрэн бүтэн дуусгаад сум орон нутгийн Засаг захиргаанд албан ёсоор хүлээлгэж өгөх хүртэл бүрэн хариуцаж ажиллана.

Төслийнхөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	2680000
ОНХС	
СБАХ	
Малчид	900000
Нийт	3580000



Худгаа сумын комиссд хүлээлгэж өгөв.



Худгийн анхы байдал



Худгийн цооногт хамгаалалт барих гэж материалаа татаж байгаа нь



Худгийн гүйцэтгэлийн явц



Худаг бэлэн болж мал усалж байгаа нь

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	цемент	уут	5	18000	90000
2	Дээвэр хийх банз \5м\	ш	20	15000	300000
3	Блок	ш	250	1500	375000
4	хаалга	ш	1	85000	85000
5	цонх	ш	1	30000	30000
6	хадаас	кг	2	5000	10000
7	50 метрийн гүнээс сорох насос	ш	1	350000	350000
8	Каблын утас	м	60	5500	330000

9	Ус дамжуулах хоолой	м	60	5000	300000
10	Татуурга тросс	м	60	2800	168000
11	Цахилгааны утас	м	15	2000	30000
12	Тог баригч кускател 100 кв	ш	1	80000	80000
13	Мотор 220 кв 5.5вт	ш	1	500000	500000
14	Онгоц хийх төмөр	ш	10	18000	180000
15	Тээврийн зардалд				250000
16	Ажилчдын хоолны зардал	Хүн.хоног	20	15000	300000
17	Ажлын багаж хэрэгсэл	багц			140000
18	Дээврийн төмөр	9			62000
19	Нийт дүн				3580000

ТӨСЛИЙН ҮР ДҮН

- Уг гүн өрмийн цооногийг хамгаалж насос мотор тавьж ажилд оруулсанаар усны гачигдалыг багасгах ач холбогдолтойгоос гадна Цагаан уул БАХ-ийн 17 малчин өрхийн ундны ус болон тэдгээрийн бод бог нийлсэн 20 гаруй мянган малыг усаар хангаж, ашиглагдахгүй байгаа 45 га бэлчээрийг ашиглах боломж бүрдэж байгаа юм. Мөн хашиж хамгаалж амсар таг хийснээр эрүүл ахуйн шаардлага хангасан ус хэрэглэх боломж бүрдэнэ. Уг гүн өрмийн цооногийг хамгаалж насос мотор тавьж ажилд оруулсанаар Цагаан-Уул БАХ-ын малчид усны гачигдалгүй болно
- Ээлж дараатай ашигласнаар нэг дор 1000-2000 мал услах гэж урт удаан хугацаанд хүлээж ойр орчмын бэлчээрийг талхлах явдал арилна
- Цагаан-Уул БАХ-ын 20 шахам малчид сүүлийн 3-4 жил бараг ашиглагдаагүй нутаг бэлчээрээ амар тайван ашиглах нөхцөл бүрдэнэ.
- Малчид хамгаалалт сайтай цооног бүрэн бүтэн амсар таг сайтай эрүүл ахуйн шаардлага хангасан ус хэрэглэх боломж бүрдэнэ.
- Цагаан уул БАХ-ын хаваржаа намаржааны ашиглагдахгүй байгаа 16000 га газрыг ашиглах боломж бүрдэнэ.
- Цаашид худгаа түшиглэн тэжээлийн ургамал тариалах нөхцөл бүрдэнэ.
- Цагаан уул БАХ нь 2019 оны 6 сард сүргийн эргэлтийн төлөвлөгөөг хийснээр 2019 оны жилийн эцсээр нийт мал сүргийн тоо 0.2% буурсан. Малчид энэ тал дээр санал санаачлага гарган сайн ажилласаны үр дүнд сумын хэмжээнд мал сүргийн тоо урд оныхоос 9,5%-иар буурсан. Өнөө жил сумын түвшинг 15% хүргэхээр зорин ажиллаж байна.

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Төслийн үр шимийг Цагаан уул БАХ-ийн 17 малчин өрх болон тэдний ахуйн болон ундны ус тэдгээрийн бод бог нийлсэн 20 гаруй мянган мал хүртэж, усаар хангагдаж ашиглагдахгүй байгаа бэлчээрийг ашиглах боломж бүрдэж байгаа юм. Цагаан уул БАХ-ийн малчин П.Эрдэнэцогт: Та бүхэндээ маш их баярлалаа. Манай энд чинь хавар болохоор хур бороо бага ордог учраас усны гачаалд ороод байдаг юм. Ийм сайхан худгийг сэргээн засварлаж ажилд оруулж өгсөн төслийн хамт олондоо маш их баярлалаа гэж сэтгэл хангалуун ярьж байлаа.

Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага:

Сүүлийн жилүүдэд говь хээрийн нутагт цас бороо орох нь багассан, хавар намрын улиралд тухайн худаг ашигладаг малчдаас гадна хол ойр нүүдэл хийж дайран өнгөрөх малчид нэмж ашиглах зайлшгүй шаардлагатай чухал хэрэгцээт худаг бол Цагаан-Уул БАХ-ын хаваржаа намаржааны бүс нутагт байрлах Гашууны худаг юм. Уг худгийн жинхэнэ ашиглагч нь тус БАХ-ын 17 малчин өрх бөгөөд эдгээрийн 14,5 мянган малыг хаврын улиралд 60 хувь, намрын улиралд 100 хувь усаар хангадаг, 50 метр гүн ундарга сайтай шавхагддаггүй бараг сайн чанарын устай манай БАХ-ын амин худаг мөн билээ.

Гэтэл цаг уурын өөрчлөлтийн дагуу цас бороо орох нь багассан, бэлчээрийн хомсдол бий болж байгаагаас малчдын хол ойрын нүүдэл ихсэж энэхүү худгийг ашиглах зайлшгүй шаардлагатай болсон. Ингэж ашиглалт нэмэгдэж, ухвар мөчид малчид хайр гамгүй ашиглаж эдэлснээс гадуурх хамгаалалт нь нурж унасан, мөн цооног нь дарагдах аюул нүүрлээд байна. Энэ талаар малчид байнга ярьж ОНХС-ийн хөрөнгийн хуваарилтанд баг, БАХ-аасаа 1-рт эрэмбэлж өгдөг ч ОНХС-ийн хөрөнгө нь багадаад дэмжлэг авахгүй 3-4 жил болж байна.

Иймд малчид БАХ-аараа ярилцаж санал бодлоо нэгтгэн төслийн зохих дэмжлэг үзүүлэхийг хүсэж энэхүү төслийн саналыг хүргэж байна. Бид энэ худгаа хамгаалалттай болгож цооногийг нь хамгаалан насос мотортой болгосноор тодорхой эзэн хариуцаж ашиглах айл өрх малчдыг ээлж дараатай хяналттай байдлаар худаг усаа ашиглах боломж бүрдэх юм. Иймд энэхүү төслийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

Төслийн зориулалт, зарцуулалт өөрчлөгдсөн бол учир шалтгааныг тодорхой бичиж ирүүлнэ.